

“ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

Зорилго: Зөрчлийн процессын эрх зүйн хөгжил, төлөвшил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, практик хэрэгжилт, үр нөлөөг сайжруулахад чиглэсэн санал дэвшүүлэх, харьцуулсан судалгаа хийж, судлаач, практик ажилтнуудын санал, бодлыг хэлэлцэж, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлэхэд оршино

Хурлын зохион байгуулагч: Дотоод хэргийн их сургууль, Улсын ерөнхий прокурор, Цагдаагийн ерөнхий газар, Цагдаа судлалын профессорын судалгааны баг.

Хурал зохион байгуулах газар: Дотоод хэргийн их сургуулийн 606 тоот

Хурал зохион байгуулах хугацаа: 2025 оны 11 дугаар сарын 20-ны өдрийн 11.00 цагт

Хуралд оролцох байгууллага:

- Хууль зүй, дотоод хэргийн яам;
- Монгол Улсын дээд шүүх;
- Улсын Ерөнхий прокурорын газар;
- Хууль зүйн үндэсний хүрээлэн;
- Цагдаагийн ерөнхий газар
- Монголын хуульчдын холбоо;
- Монголын өмгөөлөгчдийн холбоо;
- МУИС-ийн Хууль зүйн сургууль;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
- Монгол банк
- Санхүүгийн зохицуулах хороо
- Тагнуулын ерөнхий газар
- Онцгой байдлын ерөнхий газар
- Дотоодын цэргийн штаб
- Гаалийн ерөнхий газар
- Хил хамгаалах ерөнхий газар
- Төрийн тусгай хамгаалалтын газар
- Оюуны өмчийн газар
- Нийгмийн даатгалын ерөнхий газар
- Архивын ерөнхий газар
- Их, дээд сургуулийн эрдэмтэн, судлаач, сонирхсон байгууллага.

Хурлын зохион байгуулалт: Улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлэх, эмхэтгэлд оруулах илтгэлийг Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимд цаасаар болон цахим хэлбэрээр 2025 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийг хүртэл хичээлийн I байрны 2 давхарт 210 тоот албан тасалгаанд (утас 80003733, 89898217), цахим хэлбэрээр gankhuuuranbat@gmail.com хаягаар хүлээн авч, бүртгэнэ.

Хуралд ирүүлэх эрдэм шинжилгээний ажлын сэдвийн чиглэл:

- 1.Монгол Улсын зөрчлийн процессын хөгжил, түүхэн уламжлал, цаашдын чиг хандлага;
- 2.Зөрчлийн процессын эрх зүй бие даасан салбар эрх зүйн болон хөгжих нь
- 3.Зөрчлийн процессын харьцуулсан судалгаа
- 4.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал
- 5.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардал, тулгамдсан асуудал
- 6.Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих прокурорын хяналт
- 7.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал
- 8.Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа, тулгамдсан асуудал
- 9.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны оролцогч, тэдгээрийн эрх, үүрэг
- 10.Зөрчил шалгах тодорхой ажиллагаа явуулах журам, тулгамдаж буй асуудал;
- 11.Эрх хязгаарлах арга хэмжээ, тулгамдаж буй асуудал
- 12.Шийтгэл ноогдуулалт, тулгамдаж буй асуудал;
- 13.Шүүхийн зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа, тулгамдаж буй асуудал
- 14.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эмзэг мэдээлэл, төрийн болон албаны нууцыг хамгаалах ажиллагаа, тулгамдаж буй асуудал
- 15.Шийтгэлээс чөлөөлөх үндэслэл, журам, тулгамдаж буй асуудал
- 16.Тусгай журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, тулгамдаж буй асуудал
17. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны олон улсын туршлага
- 18.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд газар дээр нь шуурхай шийдвэрлэх боломж, тулгамдаж буй асуудал
- 19.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хиймэл оюун ухаан ашиглах хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудал
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь хүний эрхийн баталгаа
- 20.Бусад

Илтгэлд тавигдах ерөнхий болон техникийн шаардлага:

- 1.Хэлбэрийн хувьд:
 - Илтгэл нь нэр, зохиогчийн овог, нэр, цахим хаяг, товч хураангуй, түлхүүр үг (англи хэл, монгол хэлээр), оршил, судалгааны ажлын үр дүн буюу үндсэн хэсэг, дүгнэлт, санал, хавсралт, ном зүй зэргээс бүрдэнэ.
 - Үндсэн хэсэгт илтгэгчтэй холбоотой мэдээллийг тусгахгүй бөгөөд илтгэл нь А4 хэмжээний 0,5-1,5 х.х буюу 8-10 нүүр бүхий “Arial-12”, “1.15 pt”-ээр бичигдсэн байна.

-Илтгэлийн цахим хувилбарыг хавсарган ирүүлнэ.

2.Агуулгын хувьд:

-Тухайн асуудлыг онол, практикийн үүднээс судлан боловсруулж, тодорхой үр дүнд хүрсэн, түүнийгээ шинжлэх ухааны үүднээс үндэслэлтэй нотлох;

-Судалгааны шинэлэг тал, практик ач холбогдлыг тодорхойлох;

-Дэвшүүлсэн санал, дүгнэлт оновчтой, практикт нэвтрэх, хэрэгжих боломжтой байх;

3.Илтгэлд тавигдах техник шаардлага:

-Microsoft Office Word, Arial, үсгийн хэмжээ 11, хуудасны зүүн талаас 3.0 см, дээд доод талаас 2.0 см, баруун талаас 1.15 см зайтай, А4 формат, мөр хоорондын зай 1.15 байна. Илтгэгч овог, нэр, албан тушаал, холбоо барих утас, цахим хаягаа бичнэ. Илтгэлийг хамтран бичиж оролцож болно.

-8-12 тал байна;

-Илтгэлийн эхийг хэвлэмэл болон цахимаар хүлээн авна;

-Ирүүлсэн илтгэлийг шүүн хэлэлцэж, хурлын эмхэтгэлд хэвлэнэ.

Хурлын үр дүн: Илтгэлийн онол, практикийн ач холбогдлыг тодорхойлж, сэдэв, чиглэлийн дагуу зөвлөмж боловсруулан, эрдэм шинжилгээ, судалгаа, практик үйл ажиллагаанд эргэлтэд оруулж, зөвлөмжийг цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

Шагнал, урамшуулал:

10 илтгэлийг шалгаруулж, мөнгөн шагналаар урамшуулна.

Холбоо барих утас: Утас: 80003733

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

Дотоод хэргийн их сургуулийн
захирлын 2025 оны . . . дүгээр
сарын . . . -ны өдрийн дугаар
тушаалын 3 дугаар хавсралт

ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	ЗАРДЛЫН ЗҮЙЛ	ЗАРДЛЫН ДҮН /төгрөгөөр/
1	Илтгэлийн урамшууллын зардал	1,000,000.00
	Шилдэг илтгэлийн урамшуулал (10 хүн * 100,000₮)	1,000,000.00
2	Шүүгчийн зардал	420,000.00
	Шүүгчийн урамшуулал (4 хүн * 105,000₮)	420,000.00
3	Бичиг хэргийн зардал	
	Батламж 10 ширхэг, хурлын эмхэтгэл 20 ширхэг, брошюр, мандат, урилга (Хэвлэл, редакцын албаар хэвлүүлэх)	
БҮГД ДҮН		1,420,000.00

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ